

ХУВЬЦАА ХЭРХЭН ХУДАЛДАН АВАХ БЭ?

“Нако түлш” ХК нь үйлдвэрийн угсралтын ажлыг дуусган ашиглалтанд оруулах, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхээр нэг бүр нь 229 төгрөгийн үнэтэй 1,615,721 ширхэг энгийн хувьцааг нэмж гаргаж байна.

Нэмж гаргаж буй энгийн хувьцааг доорхи байдлаа нийтэд санал болгож байна.

- “БиДиСЕК”ХК, “Эм И Ти Эф” ХХК-ийн хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний дагуу оруулсан нийт 99,735,550 сая төгрөгийн зээлийг нэг бүр нь 229 төгрөгийн үнэтэй 435,526 ширхэг хувьцаанд хөрвүүлэх
- Нийтэд нээлттэй худалдагдах 1,180,195 ширхэг энгийн хувьцааг нэг бүрийг нь 229 төгрөгөөр нийтэд худалдах.

	Ажлын дараалал	Хугацаа
1	Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр	2010 оны 8 сарын 25-ны 235 тоот тогтоол
2	Монголын Хөрөнгийн Биржийн шийдвэр гарах	Ажлын 30 хоног
3	Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх хугацаа	2010 оны 8 сарын 25-ны өдрөөс 2010 оны 10 сарын 6-ны өдрийг дуустал ажлын 30 хоног
4	МХБ-ээр дамжуулан олон нийтэд санал болгон арилжих	Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх ажлын 30 хоногийн хугацаа дууссаны дараа

2009 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын бүртгэх өдөр буюу 2009 оны 8 сарын 12-ны өдрөөр хувьцаа эзэмшиж байсан хувьцаа эзэмшигчид компанийн тухай хуулийн 35.1.4 болон 39 дүгээр зүйлд заасны дагуу нэмж гаргаж буй энгийн хувьцаанаас хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

- Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэхдээ харьяа брокер, дилерийн компанидаа захиалга өгч, хувьцаа тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх мэдэгдэл, хувьцааны үнийг төлсөн баримт хамт “Нако түлш” ХК-д ирүүлнэ.
- Тэргүүн ээлжинд худалдан авах хувьцааны арилжаа хоёрдогч зах зээлийн арилжаанаас тусдаа зохион байгуулагдана.
- Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх талаар мэдэгдээгүй нөхцөлд тухайн хувьцааг хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжинд худалдан авах эрхээсээ татгалзсанд тооцож, хувьцааг МХБ-аар нийтэд санал болгон худалдан борлуулна.
- Нэмэлт хувьцааны талаар дэлгэрэнгүй мэдээг: Харилцагч нар өөрийн харьяа брокер, дилерийн компаниуд болон хөрөнгө оруулалтын зөвлөх, Андеррайтер, Брокер, Дилерийн БиДиСЕК ХК-ээс мөн www.bdsec.mn, www.naco.mn, www.mse.mn сайтуудаас авч болно.